



САНГИЙН САЙД  
З.МЭНДСАЙХАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛГА

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай 1,  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 70 16, Факс: (976-11) 32 70 16,  
Цахим шуудан: stategreathural@parliament.mn,  
Цахим хуудас: www.parliament.mn

2026.04.20 № 18

Эрүүл мэндийн салбарын  
зардлын талаар

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.2 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасны дагуу гишүүн нь Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүдээс хууль тогтоомжийн биелэлтийг хэрхэн зохион байгуулж, ямар үр дүнд хүрсэн талаар мэдээлэл авах зорилгоор бичгээр асуулга тавих эрхтэй. Уг асуулга нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.16, 8.1.17-д заасан мэдээлэл авах харилцаанаас ялгаатайгаар бодлогын хэрэгжилт, үр дүн, санхүүжилтийн бодит байдалд чиглэж байгаагаараа онцлог болно.

Эрүүл мэндийн салбарын санхүүжилт нь хүн амын эрүүл мэндийг хамгаалах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлэхэд шийдвэрлэх ач холбогдолтой бөгөөд Монгол Улсыг 2026–2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг 2027 онд Дотоодын нийт бүтээгдэхүүний 5 хувьд хүргэх зорилтыг тусгасан боловч уг зорилтыг хангах санхүүжилтийн бодлого, эх үүсвэр, хэрэгжилтийн үе шат, дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн талаар тодорхой мэдээлэл авах шаардлагатай байна. Иймд Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

1. Эрүүл мэндийн салбарын төсвийг нэмэгдүүлэх бодлого нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд ямар зарчим, шалгуур үзүүлэлтэд үндэслэн ямар тооцооллын аргачлалд тулгуурлан төлөвлөсөн талаар дэлгэрэнгүй мэдээлэл;

2. “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д эрүүл мэндийн салбарын төсвийг 2027 онд Дотоодын нийт бүтээгдэхүүний 5 хувьд хүргэх зорилтыг тусгасан, дээрх зорилтыг хэрхэн хангах талаарх тооцоо, төлөвлөлтийн талаар;

3. Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын цалингийн нэмэгдлийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Сангийн яамнаас тооцоолж буй төсөв, бодлогын байр суурь, уг нэмэгдлийг санхүүжүүлэх эх үүсвэр, төсвийн хүрээнд хэрэгжих боломж, дунд хугацаанд тогтвортой хадгалах санхүүгийн чадавхын талаар.

3026000052

Эдгээр асуудал нь эрүүл мэндийн салбарын тогтвортой санхүүжилт, хүний нөөцийн бодлого, иргэдийн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанарт шууд нөлөөтэй тул бодит мэдээлэл, тоон үзүүлэлт, судалгаанд суурилсан хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасан хугацаанд ирүүлэхийг хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



Т. МӨНХСАЙХАН

2026000052